



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.10 № 3/407
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дорнод бүсийн эрчим хүчний сүлжээ" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдлын, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгад аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Дорнод бүсийн эрчим хүчний сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Дорнод бүсийн эрчим хүчний сүлжээ" ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Дорнод бүсийн эрчим хүчний сүлжээ" ТӨХК-ийн санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Дорнод бүсийн эрчим хүчний сүлжээ" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0310SAG1 Docx

0122

070565



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ
ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**НЬЮ ЭСТИМЭЙТОР
АУДИТ ХХК**

Аудит, нягтлан бодох бүртгэлийн
зөвлөгөө өгөх итгэмжлэгдсэн
байгууллага

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Үндэсний аудитын газар:

1.САГ-ын дарга, Тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас:

2.Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

“Нью Эстимэйтор Аудит” ХХК:

1.Захирал Ж.Үхэртар
Утас: 99117097

2.Ахлах аудитор Д.Баяраа
Утас: 99359981

Хаяг: УБ хот ЧД, Ж.Самбуу-22
“Зоос гоёл” №213

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

2017 оны 02 дугаар сарын 23

АГУУЛГА:

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Шилэн дансны мэдээлэл
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дахь заалтуудыг тус тус үндэслэсэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/93 тушаалаар батлагдсан 47/2016 тоот “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний дагуу “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/-ын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явууллаа.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Компанийн гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодиттой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудитыг 2016 оны 10 дугаар сараас эхэлж, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дүгээр сарын 15-наас 02 дугаар сарын 25-ны хооронд хийхээр баталсан аудитын төлөвлөгөөний дагуу захирал Ж.Үхэртар /МНБ/, ахлах аудитор Д.Баяраа /МНБ/, аудиторын туслах Ү.Алтанзул нар хийж гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-А-9/

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-иас 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай хүсэлтээ 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 1/100 тоот албан бичгээр “Нью Эстимэйтор Аудит” ХХК-д ирүүлсэн.

“Нью Эстимэйтор Аудит” ХХК нь аудитыг Төсвийн тухай хууль болон аудитыг хийх төлөвлөгөө, хөтөлбөрт заасан хугацаанд тус тус багтаан Үндэсний аудитын газраар хянуулж, аудитын менежментийн захидлыг “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын Төсвийн тухай, Эрчим

хүчний тухай хууль, Татварын багц хуулиуд, Нийгмийн даатгалын тухай хууль, бусад хууль, Засгийн газрын тогтоол, салбарын Сайдын гаргасан тушаал шийдвэр болон бусад нийтлэг заавар, журмыг мөрдөж үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт орсон өөрчлөлтийн хувьд:

- УИХ-аас 2015 оны 06 дугаар сард Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шинэчлэн баталж 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан байна. Мөн НББ-ийн тухай хууль батлагдсантай холбогдуулан бусад дагалдах хуулиудад өөрчлөлт орсон байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

3.1 Зорилго:

Компанийн эрхэм зорилго:

“Тусгай зөвшөөрлөөр олгосон үйл ажиллагааны бүхий л хүрээнд удирдлагын оновчтой арга барилаар байгууллагын зан төлөв, соёлыг төлөвшүүлж, бүс нутгийн эрчим хүчний хэрэглээний өсөлтийг цаг ямагт дэмжин, найдвартай тасралтгүй үр ашигтай үйл ажиллагаагаараа эрчим хүчний салбарт нэр хүнд бүхий компани болоход тус байгууллагын эрхэм зорилго оршино.”-гэж тодорхойлсон байна.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 1969 онд Дорнод аймгийн Дулааны цахилгаан станц нэртэй, 12 меговаттын хүчин чадалтайгаар анх ашиглалтанд орж, 1979-1980 онд 36 меговатт цахилгаан, 330 т.цаг уур үйлдвэрлэх хүчин чадалтай болж өргөтгөл хийгдэж байжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК болж шинээр зохион байгуулагдсан байна.

2004 оноос эхлэн Дорнод, Сүхбаатар аймгуудын нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулалттай “Шанлун”, “Цайрт минерал”, “Улааны орд”, “Эмээлт Майнз”, “Эм Эл Цахиурт овоо”, “Петро Чайна Дачин Тамсаг” зэрэг уул уурхайн томоохон компаниуд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2020 он хүртэлх цахилгааны урьдчилан өгсөн захиалгаар 104,5МВт хүргэхээр зорилт тавин ажиллаж ирсэн байна.

3.2 Үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл

3.2.1 Удирдлага, зохион байгуулалтын талаар:

2016 оны 6 дугаар сард болсон Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр Засгийн газар шинээр зохион байгуулагдсантай холбоотойгоор Эрчим хүчний яаманд бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөлт хийгдсэн. Мөн Яамны бүтцээс гадна, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шинээр байгуулагдаж Төрийн өмчит хуулийн этгээд болох Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг шинээр томилох ажлууд хийгдсэн байна.

2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хуралдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 02 тоот тогтоолоор “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр байгуулсан байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн хурлын 14 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн даргаар Ц.Түвшинзаяа /ТӨБЗГ-ын хэлтсийн дарга/-г томилсон байна. Харин энэ өдрийн хурлын 15 дугаар тогтоолоор Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Ч.Чинбатыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, 16 дугаар тогтоолоор Г.Отгонбаатарыг гүйцэтгэх захирлаар томилсон байна.

Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын 02 өдрийн б/311 дүгээр тушаалаар ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан У.Энхчимэгийг ерөнхий нягтлан бодогчийн үүрэгт ажлаас чөлөөлж, тооцооны нягтлан бодогчоор ажиллуулахаар, Орлогч нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Гэрэлчулууныг ерөнхий нягтлан бодогчоор томилон ажиллуулж байна.

3.2.2 Үйл ажиллагааны талаар:/компанийн мэдээллээр/

3.2.2.1 Үйлдвэрлэлийн хувьд:

а. Боловсруулсан цахилгаан эрчим хүч /ЦЭХ/:

Тайлант хугацаанд 180.7 сая.кВтц цахилгаан эрчим хүч боловсруулахаас 213.5 сая кВтц цахилгаан эрчим хүч боловсруулж төлөвлөгөөг 118.2%-иар биелүүлж ажилласан. Цахилгаан эрчим хүчний боловсруулалт 32.8 сая.кВтц-аар нэмэгдсэн байна.

б. Эрчим хүчний түгээлт: ЦЭХ, Дулааны эрчим хүч /ДЭХ/

ЦЭХ-ний түгээлтийн талаар: Тайлант хугацаанд өөрийн түгээлт 182.8 сая.кВтц цахилгаан эрчим хүч түгээж, 32.6 сая.кВтц буюу 121.7 %-иар давуулан биелүүлсэн байна.

ДЭХ-ний түгээлтийн талаар: Тайлант хугацаанд 273.3 мян.Гкал дулааны эрчим хүч түгээж төлөвлөгөөнөөс 40.9 мян.Гкал буюу 117.6%-иар давж биелүүлсэн байна. Дулааны түгээлт өссөн нь сүлжээний шууд усны зарцуулалт 2014 оны дунджаас 80.0 тн/ц-аар нэмэгдэж, өвлийн ачааллын үед 1370-1380 тн/ц хүрч байгаа ба орон сууцны байшин болон бусад хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотой гэсэн тооцоог гаргасан байна.

в. Дотоод Хэрэгцээний Цахилгаан Эрчим Хүчний зарцуулалт:

Нийт боловсруулсан цахилгаан эрчим хүчний 14,4% буюу 30.6 сая.кВтц-ийг дотоод хэрэгцээнд зарцуулж, ЭХЗХорооноос баталсан хувь хэмжээнээс 2,5 пункт, өмнөх оныхоос 1.4 пунктээр бууруулж ажилласан байна.

г. Түгээлтийн шугамын алдагдал:

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ 43.9 сая кВтц-аар нэмэгдэж, түгээлтийн шугамын алдагдал Эрчим хүчний зохицуулах газраас тогтоосон хувь хэмжээнээс 1.1 пунктээр буурсан гэсэн үзүүлэлт гарсан байна.

3.2.3.2 Санхүүгийн хувьд:

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 67.6 сая төгрөг, дансны авлага 33.4 сая төгрөг,

бусад авлагаар 324.7 сая төгрөг, бараа материалын үлдэгдэл 998.6 сая төгрөг нийт 1,424.8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Оны эхэнд үндсэн хөрөнгө 96,945.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант ондоо 6,399.1 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 802 дугаар тогтоолоор Дорнод аймаг дахь Гаалийн газар, салбар боомтуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 108.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж авсан байна.

Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 325 дугаар тогтоолоор 237.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг, 4.5 сая төгрөгийн биет бус хөрөнгийг тус тус акталсан байна.

Санхүүгийн тайлангаар эргэлтийн бус хөрөнгийг 57,672.0 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 53 дугаар тогтоолоор баталсан Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журмыг мөрдөж ирсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн тушаалаар 2016 оны жилийн эцсийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг тоолох комиссыг томилон тооллогыг хийж дуусгасан байна.

Санхүүгийн тайланд богино хугацаат өр төлбөр 962.5 сая төгрөг, урт хугацаат өглөгийг 16,065.3 сая төгрөгийн, эзний өмчийн дүн 39,410.2 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тус тус тайлагнагдсан байна.

Авлагын дансны томоохон дүнтэй байгууллагын хувьд:

- Сангийн яамнаас Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн авлага – 319.4 сая төгрөг буюу 89,2%
- Айл өрхийн ЦДЭХ-ийн авлага 16.1 сая төгрөг буюу 4,4%-ийг тус тус эзэлж байна.

Богино хугацаат өглөгийн дансны томоохон дүнтэй байгууллагын хувьд:

- Диспетчерийн үндэсний төвд – 75.3 сая төгрөг,
- Восток энерго монтаж ХХК-д 51.1 сая төгрөг ,
- 9-н ААНБ-д 179,1 сая төгрөг ,
- Адуунчулуут ХК-д нүүрсний төлбөр- 295.6 сая төгрөг ,
- Импортын цахилгааны өглөг – 90.5 сая төгрөг

Урт хугацаат өглөгийн хувьд:

- Германы сэргээн босголт банк -2015 оны өглөгийн үлдэгдэл хэвээр-7,741.0 сая төгрөг
- Дэлхийн банк -2015 оны өглөгийн үлдэгдэл хэвээр- 2,210.4 сая төгрөг
- Дэлхийн банк -2015 оны өглөгийн үлдэгдэл хэвээр- 573.4 сая төгрөг
- Германы сэргээн босголт банк –зээлийн хүүгийн өглөг – 66.6 сая төгрөг
- Дэлхийн банк - зээлийн хүүгийн өглөг – 21.8 сая төгрөг

Хойшлогдсон орлого:

- Өөрийн /2015 оны өглөг хэвээр/ -1,436.9 сая төгрөг
- Өөрийн - 4,103.4 сая төгрөг- тус тус эзэлж байна.

Бид Компанийн гүйцэтгэх удирдлага болон байгууллагатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хууль, бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг тус тус хэрэгжүүлэн ажилласан байна. /ТАБ-СТА-А-1/

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, тогтоол, заавар, журмыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 15-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/322 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Дотоод хяналт:

Аудитаар тус компанийн дотоод хяналтын системийн зохион байгуулалт, дотоод аудиторын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа, мөн удирдлагын зүгээс хяналтыг гүйцэтгүүлэх, гарсан зөрчил дутагдлыг арилгах зэрэг арга хэмжээний талаар нягтлах үүднээс хяналтын албаны үйл ажиллагаатай танилцан шалгасан болно.

Өөрөөр хэлбэл Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Эрчим хүчний Сайдын 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 40 дүгээр тушаалын дагуу компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Дотоод хяналтын алба байгуулж, бүтэц орон тоог 2 хүнтэй байхаар батлуулсан байна.

Хяналтын алба нь гүйцэтгэх удирдлагын дэргэд бусад хэлтэс, албадаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахаар бүтэц, зохион байгуулалтын хувьд зохицуулагдсан

ба 2016 оны 1 дүгээр сард дотоод хяналт явуулах шинэчилсэн журмыг батлуулж, удирдамжийн дагуу шалгалтыг гүйцэтгэж ирсэн байна.

2016 онд хяналт шалгалтын 13 ажил хийх төлөвлөгөөг батлуулж, шалгалтаар 29 зөрчил дутагдлыг илрүүлэн 10 зөвлөмжийг хүргүүлж ажилласан тухай шалгалтын тайланг Захирлын зөвлөлийн хуралд оруулж тайлагнасан байна.

Аудитын явцад Хяналт шалгалтын албаны даргад болон шинээр ажилтан авахдаа санхүүгийн мэргэжлийн хүмүүсийг авах, тэдгээрийг мэргэшүүлэх чиглэлээр давтан сургах шаардлагатай байгаа талаар зөвлөгөөг өгч ажиллалаа.

Төлөвлөгөөний орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Компани өөрийн үйл ажиллагаанд 38,479.5 сая төгрөгийн орлого олж, 35,490.4 сая төгрөгийн зардал гарган, 2,989.2 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. /Хүснэгтээр/

“ДБЭХС” ТӨХК-ИЙН 2016 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТИЙН ТУХАЙ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 он	2016 он		төлөвлөгөөнөөс	
				Төлөв	Гүйц	дүн	хувь
1	Боловсруулсан ЦЭХ	сая.кВтц	184.7	180.7	213.5	32.8	118.2
2	ЦЭХ-ний түгээлт	сая. кВтц	163.9	180.5	224.5	44.0	124.4
	Өөрийн түгээлт	сая. кВтц	155.5	150.2	182.8	32.6	121.7
	ЦДҮС-ээс ХАЦЭХ	сая. кВтц	4.10	28.93	39.26	10.3	135.7
	Импортын ЦЭХ	сая. кВтц	4.3	1.4	2.4	1.0	174.5
	ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	257.2	232.4	273.3	40.9	117.6
3	Дотоод хэрэгцээний ЦЭХ	хувь	15.80	16.80	14.40	(2.4)	116.7
4	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувь	7.2	7.3	5.0	(2.3)	146.0
5	Нийт орлого	сая.төг	27,747.4	30,611.0	38,479.6	7,868.6	125.7
	Үүнээс:Борлуулалтын орлого	сая.төг	24,687.0	29,744.5	36,833.0	7,088.5	123.8
6	Нийт зардал	сая.төг	26,104.3	29,788.6	35,490.4	5,701.8	119.1
	Үүнээс:Удирдлагын зардал	сая.төг	327.6	189.7	218.2	28.5	115.0
7	Татвар төлөхийн өмнөх ашиг, / алдагдал/	сая.төг	1,643.1	822.4	2,989.2	2,166.8	363.5

8	Цэвэр ашиг /алдагдал /	сая.төг	1,580.1	740.2	2,889.2	2,149.0	390.3
9	БО-ын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.9408	0.9731	0.9223	(0.051)	- 0.018
10	Нийт авлага	сая.төг	1,988.3	100.0	358.4	258.4	358.4
11	Нийт өглөг	сая.төг	19,043.9	1,200.0	17,038.7	15,838.7	1,419.9
	Үүнээс : Богино хугацаат өглөг	сая.төг	1,412.5	800.0	973.4	173.4	121.7
12	Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХ	сая.төг	4,007.1	6,458.1	6,163.7	(294.4)	95.4
13	Түлшний хувийн зарцуулалт ЦЭХ	гр/квтц	642.8	676.2	636.8	(39.4)	106.2
	ДЭХ	кг/гкал	192.0	194.3	191.7	(2.6)	101.4
14	Аваар саатал	сая.төг	1.0	-	-	-	-
15	Нийт ажиллагсдын тоо	гр/квтц	596	602	617	15.0	102.2
16	Нийт цалингийн сан	кг/гкал	7,479.4	8,859.7	9,939.1	1,079.4	112.2

Ашигтай ажиллахад нөлөө үзүүлсэн хүчин зүйл:

- Эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөлтөөс шалтгаалан үйлдвэрлэлийн үйл ажиллагааны орлого нэмэгдсэн байна.
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбогдуулан борлуулалтын зардлууд төлөвлөснөөс өссөн байна.
- Компанийн эрчим хүчний томоохон хэрэглэгч болох Тамсагийн газрын тосны орд газрын ХХI талбай ашиглалтанд орсноор цахилгаан эрчим хүч хэрэглээ нэмэгдсэнээр цахилгаан түгээлтэд эерэг нөлөө үзүүлж үйлдвэрлэлийн хэмжээ 32.8 сая квтц-аар өссөн байна.

6. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3-р бүлэгт заасны дагуу “ДБЭХС” ТӨХК нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн журмыг батлан мөрдөж мэдээллийг нийтэд ил тод мэдээллэх нийтлэг стандарт шаардлага, түүнтэй холбогдон гарах эрх зүйн харилцааг зохицуулан энэ ажлыг Дотоод хяналтын албанд хариуцуулан ажиллаж байна. Тус байгууллагад шилэн дансны хуулийн дагуу мэдээллийг компанийн вэбсайтад байршуулах ажлыг Санхүү Бүртгэлийн Хэлтэс(СБХ), Хангамж Үйлчилгээний Хэлтэс(ХҮХ), Захиргаа Удирдлагын хэлтсийн холбогдох мэргэжилтэнүүд байршуулж, мэдээллийн үнэн зөв байдалд дотоод хяналтын алба хяналт тавин ажиллаж байна. Эрчим хүчний яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2016 онд шилэн дансны мэдээлэлтэй холбоотой шалгалтыг хийж, үнэлгээ дүгнэлт гарган зөвлөмж өгч ажилласан байна. Үүнд:

- “ДБЭХС” ТӨХК нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд багтах байгууллагуудын нэгдсэн сайтад бүрэн хамрагдсан байна.

- Компанийн дотоод аудитын албанаас хяналт тавьж ажиллан холбогдох зөвлөмжийг өгдөг ба түүнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.- гэж тус тус дүгнэсэн байна.

Харин тус компани нь шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 4.1.7-д заасан нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зарчмаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9-р зүйлд заасан мэдээллийг дутуу мэдээлсэн гэсэн дүгнэлт гарган зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсөн байна.

Аудитын явцад 2017 оны 02 дугаар сарын шилэн дансны мэдээллийн талаар холбогдох хууль, журам, зааврын дагуу ажиллаж байгаа эсэхийг шалгахад Шилэн дансны тухай хуулийн дагуу бүх мэдээллийг оруулсан байна. Тус мэдээллийг <http://www.shilendans.gov.mn/org/1499> холбоосоор мэдээлэл авахыг хүссэн этгээд авч болохоор байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 35 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Санхүүгийн тайлангийн жилийн хугацааг баримтлаагүй, бараа материалыг дутуу орлогод авах, өглөг бууруулах, төлөвлөгөөнд батлагдаагүй зарим зардлыг санхүүжүүлэх, орон тооны хязгаарыг давуулж ажилтан авч ажиллуулсан, дээд газрын шийдвэрээр гэх нэрийдлээр батлагдаагүй зардлыг гаргах, байгууллага хоорондын тооцоо нийлсэн актыг үйлдэхдээ дутуу гүйцэтгэх, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, зарим зардлын төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, кассын анхан шатны зарим баримтын бүрдүүлэлт дутуу зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдлүүд нь хөрөнгийн захиран зарцуулалтын эрхийг хэтрүүлэх, төсвийг хяналтгүй зарцуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байдалд хүргэж болно.

7. Материаллаг байдлын түвшинг сонгосон үндэслэл:

Материаллаг түвшинг тогтоохдоо нийт орлого, зардлыг харьцуулж нийт зардлаас 2% буюу 711.8 сая төгрөгөөр тогтоох нь зохимжтой гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолох шаардлагагүй гэж үзсэн.

8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, борлуулалтын орлого, үндсэн бус үйл ажиллагааны орлого, өглөг, авлагын тооцоо, тогтмол зардлын тооцоо, жилийн үр дүнгийн цалин олголт, үндсэн хөрөнгийн

элэгдлийн тооцоолол, ХАОАТ, НДШ-ийн тооцооны үлдэгдэл, бараа материал/нүүрс/-ын тооцоо, урсгал зардлын зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

/ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт санхүүжилт, орлогын 75,0 нийт зардлын 65,0 эргэлтийн хөрөнгийн 60,0 нийт өр төлбөрийн 80,0 орчим хувийг тус тус эзэлж байна.

9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэсэн. Аудитын явцад дараах алдаа илэрсэн. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаа хэрхэн явагдсан, баримт материалын бүрдүүлэлт журам зааварт заасны дагуу хийгдсэн эсэх зэргийг шалгахад тендерийн баримт, материалын хувьд эмх цэгцтэй, мөн архивын нэгж болгон хадгалж байгаа нь сайн хэдий ч зарим тендерийн үнэлгээний хорооны хариуцлага хангалтгүй байгаагаас дараах нийтлэг зөрчлийг гаргасан байна. Үүнд:
 - Тендер шалгаруулах явцад Харьцуулалтын аргаар худалдан авч байгаа бараа, ажил үйлчилгээг журмын дагуу гурваас доошгүй харилцагчаас үнийн санал авч харьцуулалт хийсэн боловч тухайн ажил хийх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон байгууллагын гэрчилгээ байхгүй, татварын албаны тодорхойлолтгүй, баримтын бүрдэл дутуу байхад гэрээ хийгдсэн зөрчил гаргасан байна.
 - Нийтдээ харьцуулалтын аргаар 59 бараа, ажлыг худалдан авснаас 45-ийг нь түүвэрлэн авч Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалаар баталсан журмын дагуу хийгдсэн эсэхийг шалгахад 31 ажил буюу 68,8 хувь нь журамд ззасан өгөгдлийн хүснэгтийг орхигдуулсан байна.
 - Хангамжийн хэлтэс нь хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ, бусад бараа бүтээгдэхүүний үнэ ханшийн судалгааг өөрсдөө хийж төлөвлөгөөг батлуулах талаар хангалтгүй ажилласан байна.

Шийдвэрлэсэн: 1) Харьцуулалтын аргаар бараа, ажлыг худалдан авахдаа Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалаар баталсан заавар, журмын дагуу гүйцэтгэх. 2) компанийн хэмжээнд үнийн судалгааны асуудлыг Худалдан авах ажиллагааны буюу хангамжийн хэлтэст дагнан хариуцуулах гэсэн зөвлөмжийг өгсөн.

